



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Төмөр Замын дээд сургууль

Сургалтын хөтөлбөрийн нэр: Төмөр замын цахилгаан холбоо,
телемеханик

Индекс: D071403

Шинжээчийн баг:

Ахлагч: З.Буянхишиг

Гишүүд: Ж.Хүрэл

Д.Мянганбаатар

2019.05.28

Агуулга

Товчилсон үгийн тайлбар	3
I. Магадлан шинжлэх үйл явц, төлөвлөлт	4
II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга	5
III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт	5
Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт.....	5
Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа.....	7
Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл.....	10
Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт.....	12
Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа.....	15
Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа.....	18
Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт.....	21
Дүгнэлт.....	23
Ерөнхий зөвлөмж.....	24
IV. Уулзалтад оролцогчдын нэрс	24
I. Багш нарын нэрс.....	24
II. Оюутнуудын нэрс.....	25
III. Ажил олгогчдын нэрс.....	26
IV. Төгсөгчдийн нэрс.....	26
V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал	27
VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр	28
VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр	28

Товчилсон үгийн тайлбар

БСШУСЯ – Боловсрол Соёл Шинжлэх Ухаан Спортын Яам

ЗТЯ – Зам Тээврийн Яам

ТЗДС – Төмөр Замын Дээд Сургууль

УБТЗ – Улаанбаатар Төмөр Зам

ХНН – Хувь Нийлүүлсэн Нийгэмлэг

ШУТИС – Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль

ЗХИС – Зам Харилцааны Их Сургууль

CDIO – Concieve Design Implement and Operate

ЕБС – Ерөнхий Боловсролын Сург ууль

ИДС - Их Дээд сургууль

ЭШОП – Эрдэм Шинжилгээ Онол Практик

I. Магадлан шинжлэх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Төмөр Замын Дээд Сургууль, Railway Institute of Mongolia	
Хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Төмөр замын цахилгаан холбоо, телемеханик Railway telecommunication, telemechanics	
Индекс	D071403	
Шинжээчид	<p>Ахлагч: З.Буянхишиг /ШУТИС-ийн Мэдээлэл Холбооны Технологийн сургуулийн Холбооны салбарын эрхлэгч/</p> <p>Гишүүд: Ж.Хүрэл /ҮБХИС-ийн Аюулгүй байдлын Сургуулийн Холбоо, электроникийн тэнхимийн эрхлэгч/</p> <p>Д.Мянганбаатар /Мэдээлэл Холбооны Сүлжээ компанийн ерөнхий инженер/</p>	
БМИҮЗ-ийн зохицуулагч	Г.Даваажаргал, БМИҮЗ-ийн ажлын албаны магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд
	2019.05.06-05.13	Хөтөлбөрийн өөрийн үнэлгээг уншиж судлах, шинжээчийн урьдчилсан үнэлгээ хийх
	2019.05.16	Сургууль дээр ажиллаж нотлох баримтуудыг үзэж шалгах, сургуультай танилцах, ажил олгогч, багш нартай уулзах
	2019.05.17	Сургууль дээр ажиллаж нотлох баримтуудыг үзэж шалгах, тодруулга лавлагаа авах, оюутнууд, төгсөгчидтэй уулзах, шинжээчдийн дүгнэлт гаргах, байгууллагад танилцуулах
	2019.05.20-05.23	Шинжээчийн тайлан бичих
	2019.06.12	Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн үр дүнг Мэргэжлийн зөвлөлд танилцуулах
Шалгуур шаардлага /журам/	Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлийн дүрэм, Боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам, Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур, шаардлага	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Төмөр Замын Дээд Сургууль (ТЗДС) нь 1953 онд Төмөр замын техникум нэртэйгээр байгуулагдан төмөр замын ажилчдыг бэлтгэж эхэлсэн байна.

Сайд нарын зөвлөлийн 1962 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 652 тоот тогтоолоор Холбооны салбар байгуулагдаж, 1964 оноос Авто тээврийн болон холбооны оройн ангиудыг нээн хичээллүүлсэн байна. Төмөр замын техникум нь “Автоматик, телемеханик, ба холбооны техникч” мэргэжлээр техникчийн боловсролтой мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэж эхэлснээс энэхүү сургалтын хөтөлбөр эхлэлтэй.

1994-2004 онуудад “Дээд боловсрол олгох коллеж” болж дипломын болон бакалаврын боловсрол олгох шаталсан сургалтаар мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн бөгөөд “Төмөр замын автоматик, телемеханик ба холбоо” мэргэжлийн техникчийг 3 жилээр, бакалаврыг 5 жилээр бэлтгэж эхэлсэн. Ингэхдээ техникчийн сургалтаар суралцаж төгссөн нийт оюутнаас шилдэг 5 төгсөгчийг бакалаврын зэрэг олгох хөтөлбөрт дэвшүүлэн 2 жилээр шаталсан хэлбэрээр суралцуулдаг байсан байна. Энэ сургалтад мөн, үйлдвэрлэл дээр ажиллаж байсан шилдэг техникч нараас 5-10 хүнийг сонгон шалгаруулж, нийт 10-15 суралцагчийг жил тутам бакалаврын сургалтад сургадаг байжээ.

2004 оноос сургууль Төмөр замын дээд сургууль болж өөрчлөгдсөнөөр уг хөтөлбөр нь шаталсан сургалтаар биш 4 жилийн бакалаврын сургалтаар мэргэжилтэн бэлтгэдэг болсон.

1998 оноос хойш тус хөтөлбөрөөр бакалаврын зэрэгтэй 368 төгсөгч 17 удаагийн төгсөлтөөр төгсөн гарсан байна.

БСШУСЯ-наас 2014 онд үндэсний их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрүүдийг “багц хөтөлбөрт” шилжүүлэх ажлыг эхлүүлсэн бөгөөд энэ хүрээнд тус мэргэжлийн нэршил “Төмөр замын цахилгаан холбоо, телемеханик” болж өөрчлөгдсөн байна.

Нийт төгсөгчийн дийлэнх хувь нь УБТЗ Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэгийн харьяа аж ахуйн нэгжүүдэд ажлын байраар бүрэн хангагдан ажилладаг.

2018-2019 оны хичээлийн жилд нийт 33 оюутан уг хөтөлбөрт элссэн бөгөөд одоогоор 1-4-р курсэд нийт 92 оюутан суралцаж байна. Уг хөтөлбөрөөр суралцагчид нь жил бүрийн дотоодын ABU ROBOCON болон бусад уралдаан тэмцээнүүдэд амжилттай оролцдог.

Одоогоор хөтөлбөрийн мэргэжлийн 3 багштай, 1 багш нь ШУТИС-ийн докторант, 1 багш нь ШУТИС-ийн магистрант байна.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1 Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагыг Монголын төмөр замын хөгжлийн бодлого, шинэчлэлийн замын зураг, бодлогын бичиг баримт болон сургалтад оролцогч талуудын сонирхол, шаардлагыг тусган сайн тодорхойлон гаргасан байна.

- Хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөлт хийн, 2017 оноос ажил олгогчдоос санал асуулга авах замаар мөн хөтөлбөрийн хэлэлцүүлэг хийн мэргэжлийн эрэлт хэрэгцээг судалсан байна.
- ТЗДС-ийн “Төмөр замын цахилгаан холбоо, телемеханик” хөтөлбөрийг ОХУ-ын Москвагийн ЗХИС ба Эрхүүгийн ЗХИС-ийн “Төмөр замын автоматик ба телемеханик” хөтөлбөрүүдтэй харьцуулан дүн шинжилгээ хийж, тус хөтөлбөрүүдийн сургалтын төлөвлөгөөг харьцуулж, уг сургуулиудад заагддаг гол хичээлүүдтэй хөтөлбөрийн мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээлүүдийг жишиж, харьцуулсан бенчмаркинг судалгааг хийсэн байна.
- Хөтөлбөрийн хэрэгжүүлэлтэд SWOT шинжилгээ хийсэн байна.
- Сургалтын хөтөлбөр дэх хичээлүүдийн тоо ба багц цагийн харьцуулсан судалгаа хийх замаар нийт суурь ухааны 15 хичээл, мэргэжлийн суурийн болон мэргэшүүлэх 38 хичээлийг харьцуулан сонгож хөтөлбөртөө оруулсан байна.
- Уг хөтөлбөрөөр суралцагч нь нийт 129 кредит цагийн хичээлийг судалж байгаа нь бакалаврын сургалтын жишиг агуулгыг хангаж байгаа буюу сургалтын хөтөлбөрийн нийт кредитийн 62 хувь нь мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх хичээлүүд байгаа нь цахилгаан холбоо, телемеханик мэргэжилтэй төгсөгч бэлтгэх шаардлагад нийцнэ гэж үзэж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Байхгүй.

Анхаарах асуудал:

- Байхгүй.

Зөвлөмж:

- Байхгүй.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн зорилго, зорилтуудыг ТЗДС-ийн зорилго, зорилттой уялдуулан мэргэжлийн байгууллагуудын ажлын байранд тавигдах шаардлагуудад тулгуурлан сайн тодорхойлсон байна.
- Хөтөлбөрийн зорилго, зорилтыг тодорхойлохдоо сургалтын CDIO арга зүйд нийцүүлсэн байна.
- Уг хөтөлбөрөөр төгсөгчийн загварыг тодорхойлохдоо ажил олгогч тал буюу УБТЗ-ын аж ахуйн нэгжүүд, дохиолол холбооны ангиудад мөрддөг монтёр, мастер болон бүх шатны инженерийн болон нийтлэг холбооны болон автоматик, телемеханикийн мэргэжилтний ажлын байранд тавигдах шаардлагуудад нийцүүлэн тодорхойлсон.
- Хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлж хувь хүний төлөвшил, мэргэжлийн мэдлэг, мэргэжлийн ур чадвар гэсэн 3 бүлгээр нийт 15 суралцахуйн үр дүнг төгсөгчдөд эзэмшүүлж олгохоор тодорхойлсон байна.
- Төгсөгчдөд эзэмшүүлэх суралцахуйн үр дүн нь төгсөгчдийн онцлогтой болон хөтөлбөрийн зорилго зорилттой уялдаа холбоо сайтай байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрөөр төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг оролцогч талуудын оролцоотойгоор, салбарын мэргэжилтэнд тавигдах шаардлага, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн сайн тодорхойлсон байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрөөр эзэмших мэдлэг ур чадварын жагсаалтыг эрэмбэлэх, оновчтой болгох.
- Оюутнуудад хөтөлбөрийн зорилго, зорилтыг таниулах.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн зорилго, зорилт болон багш нарын тухай мэдээлэл, хичээлүүдийн талаарх мэдээллийг ТЗДС-ийн вэбсайтад байршуулах

1.3 Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга; сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй; сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тогтмол тусган сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- ТЗДС-ийн захирлын А-190 тоот тушаалаар 2018 онд шинэчлэн батлагдсан сургалтын төлөвлөгөөний дагуу сургалтын үйл ажиллагаа явагддаг.
- Сургалтын төлөвлөгөөний бүтэц нь ерөнхий суурь хичээл 29,5%, мэргэжлийн суурь хичээл 24,03%, мэргэжлийн хичээл 37,98% гэсэн бүтэцтэй байгаа нь БСШУСЯ-ны бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг хангаж байна.
- Уг хөтөлбөрөөр суралцагч нь нийт 129 кредит цагийн хичээлийг судалж байгаа нь бакалаврын сургалтын жишиг агуулгыг хангаж байна.
- Сургалтын хөтөлбөрийн агуулга, хичээл заалтын чанар, үр дүнгийн талаар УБТЗ-ын инженерүүд болон ерөнхий инженерийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, тэдний санал зөвлөмжийг тусган сайжруулсан байна.
- Хичээлийн хөтөлбөрүүдийг тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга; сургалтын үр дүнд чиглэсэн арга зүйг тусган сайн боловсруулсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Байхгүй.

Анхаарах асуудал:

- Сургалтын төлөвлөгөөнд CDIO арга зүйтэй холбоотой сэтгэх, бүтээх, хэрэгжүүлэх, ажиллуулах суралцахуйн үр дүнг олгоход чиглэсэн төсөлд суурилсан хичээлүүд дутагдалтай байна.

Зөвлөмж:

- Сургалтын хөтөлбөрт төсөлд суурилсан хичээлүүдийг оруулах, зарим хичээлийн агуулгад жижиг төсөл хэрэгжүүлэх агуулга нэмж өгөх нь уг хөтөлбөрөөр төгсөгчдөд сэтгэх, бүтээх, хэрэгжүүлэх, ажиллуулах суралцахуйн үр дүнг эзэмшүүлэхэд чухал ач холбогдолтой болно.

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Цаг үе, өөрчлөлт шинэчлэлтэй уялдан сургалтын төлөвлөгөөг шинэчлэн сайжруулж ирсэн. Тус хөтөлбөрөө УБТЗ-ын мэргэжлийн албаны инженер техникийн ажилтнуудаас асуулга аван мөн хэлэлцүүлж зөвлөмж авсан.
- 2017-2018 онд бусад их дээд сургуульд ашигладаг CDIO арга зүйтэй уялдуулан сургалтын хөтөлбөрийн зорилго, хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадваруудыг тодорхойлж хичээлийн стандарт хөтөлбөрийг шинэчлэн боловсруулсан.
- Хичээл бүрээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлж, сургалтын арга зүйг боловсруулсан.
- Хөтөлбөрийн шинэчлэлтийг хийхдээ хичээлүүд дэх онол практикийн зохистой харьцааг хангахад анхаарч ажилласан байна.
- Төгсөгчдийн программ хангамжийн мэдлэгийг сайжруулах зорилгоор “Алгоритм программчлал 1 ба 2” хичээлүүдийг “Программчлалын хэл” ба “Ассемблер хэл” болгон өөрчилж, кредитийг 3 болгон ихэсгэж, 2018 оноос сургалтын төлөвлөгөөндөө тусгаад байгаа нь сайшаалтай.
- Түүнчлэн УБТЗ-д дохиоллын байгууламжийг шинэчлэн сайжруулах төслийн ажил хэрэгжиж байгаатай холбогдуулан шинээр 1 хичээл оруулж стандарт хөтөлбөр боловсруулсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага

- Сургалтын хөтөлбөрийг ОХУ-ын ижил төстэй сургуулийн хөтөлбөртэй харьцуулж боловсруулсан нь сайн байна.
- Сургалтын менежментийн нэгдсэн систем UNIMIS программыг нэвтрүүлж ажиллаж байгаа нь тун сайшаалтай байна.
- Багш заах хичээлийн хөтөлбөрөө боловсруулж хөтөлбөр хариуцсан дэд профессороор хянуулж, дэд захирлаар батлуулж ажиллаж байгаа нь сайн жишээ байна.
- Хөтөлбөрийн баг байгуулан ахлагч томилон ажиллуулж байгаа сайн туршлага байна. /Мэргэжлийн салбарт 7 хөтөлбөрийн баг байна./
- Үйлдвэр дээр хийгдэх дадлага сургалтад анхаарч тусдаа дадлагын багш гэрээгээр ажиллуулж байгаа нь сайн туршлага байна.
- ОХУ-ын Москва, Иркутск хотын болон БНХАУ-ын Бээжин хотын Зам харилцааны их сургуулиуд, БНСУ-ын Тээврийн үндэсний их сургуулиудтай хамтран төгсөгчдөд хос диплом олгох хөтөлбөр хэрэгжүүлэхээр зорьж ажиллаж байгаа нь сайшаалтай байна.

Анхаарах асуудал:

- Сургалтын төлөвлөгөөний хичээл хоорондын холбоосыг өнгөөр ялгаж үзүүлсэн бүдүүвч зурагт товч тайлбар хийх /Хуудас 38, Зураг 2.1.1/

Зөвлөмж:

- Мэргэшүүлэх зарим хичээлийн хөтөлбөрийг бусад их дээд сургуулиудын холбоо, автоматик чиглэлийн болон телемеханик чиглэлийн хичээлүүдийн хөтөлбөртэй харьцуулж шинэчлэн боловсруулах
- Дохио дамжуулах онол, мэдээллийн технологи ба сүлжээ, дамжуулах систем зэрэг хичээлүүдийн агуулгыг сайжруулж орчин үеийн тоон техник шинэ дэвшилтэт технологийн талаар түлхүү оруулах.
- Хичээл тус бүрийн суралцахуйн үр дүнг тайлагнадаг, дүн шинжилгээ хийдэг байх

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн багш нар симуляцийн программуудыг ашиглан зарим семинар, лабораторийн хичээлүүдийг орж виртуал орчинд сургалтыг зохион байгуулдаг.

- Сургалтын CDIO арга зүйг нэвтрүүлэн ажиллаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш заах хичээлээ веб сайт дээр урьдчилан байрлуулж, оюутнууд хичээл заалгахаас өмнө уншаад хичээлийн явцад ойлгоогүй зүйлээ асууж тодруулах, харилцан ярилцах, мэтгэлцэх зарчмаар мэдлэг эзэмших арга хэлбэр нь сайн туршлага гэж үзэж байна.
- Лабораторийн болон дадлагын хичээлийг явуулахдаа оюутнуудыг багт хуваан хичээллүүлж байгаа нь багаар ажиллах арга барилд суралцах, бие биеэсээ харилцан суралцах арга барилд тус дэм болж байгааг сайшаан дүгнэж байна.

Анхаарах асуудал:

- Сургалтад олон улсын жишиг бүхий үндсэн сурах бичгүүдийг ашиглах

Зөвлөмж:

- Хичээлийн лекцийг бэлтгэхдээ мэдээлэл холбооны дэвшилтэт технологиудыг ашиглах нь оюутны сонирхлыг татах, тухайн сэдвийг гүнзгийрүүлэн судлах, санаа сэдэл авах, ургуулан бодох зэрэгт сайн нөлөө үзүүлнэ.

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- 2017 оны сургуулийн захирлын тушаалаар оюутны чадамжийн үнэлгээний журмыг батлахдаа шалгуулагч оюутны мэдлэгийн түвшин, ур чадвар эзэмшсэн байдал, суралцагчийн суралцах үйл ажиллагааг сайжруулах үүднээс дүгнэлт өгсөн нотлох баримтад тулгуурлан гаргасан байна.
- Суралцагчийн үнэлгээ нь онолын мэдлэг, ур чадвар, хувь хүний хөгжлийг үнэлэх аргуудаас бүрдэж дараах байдлаар хуваагдсан байна. Үүнд:
 - Ирц идэвх 15 оноо
 - Сорилт I 15 оноо
 - Сорилт II 15 оноо
 - Явц 25 оноо
 - Шалгалт 30 оноо
- Тус хөтөлбөрийн хичээлүүдэд практик туршлага, туршилтаар үнэлэх, оролцоог үнэлэх, бие даалтын ажлууд, төсөл бичих, өргөн хүрээний хариулттай асуултууд, мэргэжлийн хэлэлцүүлэг, аман илтгэл, хувьчилсан ярилцлага, шалгалт тестүүд зэрэг үнэлгээний аргуудыг ашигласан байна.
- Явцын болон улирлын шалгалтуудыг амаар болон тестээр гэсэн 2 хэлбэрээр авдаг. Улирлын шалгалтын иж бүрэн тест нь:
 - эгэл ойлголт 20 хувь
 - үндсэн хэсэг 50 хувь
 - асуудал шийдвэрлэх хэсэг 30 хувь гэсэн нийтлэг харьцаатай байдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагчийн үнэлгээг ил тод, найдвартай, шударга байлгахын тулд багшаас оюутанд 70 хүртэл оноо өгөх, үлдсэн 30 хүртэл оноог хөндлөнгийн үнэлгээгээр өгөхөөр зохицуулсан нь онцлог байна.

Анхаарах асуудал:

- Шалгалтын хэлбэр, асуулт даалгавар, сорилын санд дүн шинжилгээ хийдэг байх.
- Хөтөлбөрөөр суралцагчийн сурлагын дүн шинжилгээ болон ахиц дэвшилд анализ хийдэг байх.

Зөвлөмж:

- Багш бүр заадаг хичээл тус бүрээр улирал тутамд багшийн 70 оноо /хөндлөнгийн 30 оноонд дүн шинжилгээ хийдэг байх.

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин
Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн байр, анги танхимын тохижилт, оюутны дотуур байрны хүрэлцээ, зай хэмжээ хангалттай, эрүүл ахуйн шаардлага хангасан.
- Барилгын эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангах чиглэлээр УБТЗ ХНН-ийн Хяналтын албанаас жилд 2 удаа тогтмол үзлэг хийдэг.
- Оюутнууд чөлөөт цагаараа бие бялдраа хөгжүүлэхэд зориулсан бялдаржуулах танхимтай, давхар бүрдээ угаалгын болон ариун цэврийн өрөөтэй байгаа нь сайн үзүүлэлт болно.
- Сургуулийн хичээлийн төв байр олон жилийн өмнө баригдсан боловч барилгын чанар боломжийн сайн, сүүлийн жилүүдэд засвар үйлчилгээ сайн хийгдсэн байна.
- Хичээлийн байр, дотуур байрны сүлжээний орчин, интернет хурд, WiFi хэсэгчлэн хангалтгүй байна.
- Сургуулийн цайны газар зай талбайн хувьд бага, суудал цөөн.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Байхгүй

Анхаарах асуудал:

- УБТЗ-д нэвтэрч байгаа шинэ системтэй холбоотой лабораторийн тоног төхөөрөмж, материаллаг бааз байхгүй байна.

Зөвлөмж:

- Суралцагчдад зориулсан орчин (разетка, цэнэглэгчтэй, wi-fi)-той болох
- Мэргэжлийн хичээлийн дадлага хийхэд зориулагдсан орчин үеийн тоноглол бүхий лабораторитой болох шаардлагатай.

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн
Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Физикийн, химийн, компьютерын лабораторийн тоног төхөөрөмж багаж хэрэгсэл шаардлага хангаж байна.

- Төмөр замын цахилгаан холбоо, телемеханик хөтөлбөрт зориулсан сургалтын полигоныг УБТЗ-аас хөрөнгө гарган төгсөгчдийн дэмжлэгтэйгээр хийж тохижуулсан нь ач холбогдол бүхий сургалтын бааз суурь болсон байна.
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмж хангалттай.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Байхгүй.

Анхаарах асуудал:

- Лицензтэй программ хангамжийн асуудал
- Сургуулийн серверийн аюулгүй байдал
- Схем техникийн деталь хангах боломж

Зөвлөмж:

- УБТЗ-ын удирдлага, олон улсын байгууллагууд, гадаад дотоодын компаниуд, сургуулиудад хандаж лабораторийн материаллаг баазыг шинэчлэх боломжийг эрэлхийлэх

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургуулийн номын сан 120 гаруй суудалтай, дотуур байранд 30 суудалтай номын сантай байгаа нь хангалттай үзүүлэлт гэж тооцож байна. Номын сангийн тохижилт боломжийн.
- Номын санд тус хөтөлбөртэй холбоотой сайн сурах бичиг орос хэлээр нэлээд байгаа нь сайн үзүүлэлт боловч эдгээр сурах бичгийг зөвхөн багш нар түлхүү авч ашигладаг, оюутнуудын хэрэглээ бага байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ОХУ-ын Москва хотын Зам харилцааны их сургуулийн цахим номын санг ашиглах гэрээ хэлцэл хийгдсэн, удахгүй ашиглах бололцоо бүрдэж байгаа нь зөв зүйтэй ажил байна.

Анхаарах асуудал:

- Номын сангийн гэрэлтүүлэг, дуу чимээний стандартыг хангах
- Номын сангийн цахим үйлчилгээг хангах
- Номын санд интернэт үйлчилгээ байгаа боловч компьютерын хүрэлцээ тааруу байна.
- Орос хэл дээрх сурах бичгийг оюутнууд ашиглах нь хангалтгүй байгаад анхаарч мэргэжлийн орос хэлний хичээлийн чанарыг сайжруулах.
- Номын санд байгаа номын жагсаалтаас харахад англи дээрх сурах бичгийн хангамж хангалттай биш байна.

Зөвлөмж:

- Төгссөн оюутнууд ихэвчлэн ОХУ-Монгол улсын ХНН УБТЗ-ын харьяа байгууллагуудад ажилд ордог учраас оюутнуудын мэргэжлийн орос хэлний сургалтад онцгой анхаарч бага курсээс нь эхлэн сургалтыг системтэй зохион байгуулах.
- ОХУ-ын их дээд сургуулиудтай оюутан солилцох хөтөлбөр хэрэгжүүлж оюутны орос хэлний мэдлэгийг сайжруулах.
- Номын санд болон вестибюльд компьютер бүхий интернет уншлагын булантай болж, оюутнуудын, интернетээс мэдээлэл олж авах боломжийг нэмэгдүүлэх

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Хамгийн сүүлийн хөтөлбөрийн шинэчлэлийг 2017 онд сургуулийн захирлын А-66 тоот тушаалаар хөтөлбөр бүрээр ажлын хэсэг байгуулж 2017 оны хичээлийн жилийн хаврын улиралд хийсэн.
- Хөтөлбөрийн агуулгыг ОХУ-ын ЗХИС-уудын ижил мэргэжлийн хөтөлбөртэй дүйцүүлж, CDIO сургалтын арга зүйг нэвтрүүлж шинэчилсэн.
- Шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг УБТЗ-ын мэргэжлийн албаны болон замын ерөнхий инженерээр ахлуулсан ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлж 2017-2018 оны хичээлийн жилийн намрын улирлаас эхлэн сургалтын үйл ажиллагааг тус шинэчилсэн хөтөлбөрийн дагуу явуулж эхэлсэн.
- Хөтөлбөрийг дахин шинэчилж сайжруулах ажлыг хийж ажил олгогч, УБТЗ ХНН-ийн мэргэжлийн алба, салбар нэгжийн удирдлага, сургалт болон хөдөлмөр хамгаалал хариуцсан мэргэжилтнүүдтэй хамтран хэлэлцэж, сайжруулалт хийж ирсэн байна.
- Удирдлага мэдээллийн "UNIMIS" системийг 2017-2018 оны хичээлийн жилийн намрын улирлаас иж бүрнээр нэвтрүүлснээр оюутны сургалтын төлбөр, хичээл сонголт, дүнгийн үнэлгээ, хичээлийн хуваарь, бусад мэдээллийг хянах, дүгнэх, сайжруулахад чухал ач холбогдолтой болсон байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ОХУ-ын ЗХИС-уудын ижил мэргэжлийн хөтөлбөртэй дүйцүүлж сайжруулах ажлыг хийснээр төгсөгчдийн чанар сайжирч шатлалтай суралцах буюу ахисан түвшинд суралцах боломж бүрдсэн.
- Оюутанд кредитийн хүндрэлгүйгээр дэвшин суралцах боломжийг бий болгосон.
- 2018 оноос тэнхимийн бүтцийг мэргэжлийн хөтөлбөрийн баг болгон өөрчилж дэд профессороор ахлуулж мэргэжлийн салбарт нэгтгэсэн.
- Удирдлагын баг хөтөлбөрийн сайжруулалтад сайн менежменттэй.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн мэргэжлийн багшийн тоо цөөн, хэт их ачаалалтай.
- Лабораторийн хичээлийн хувьд сургалтын мастер, лаборант байхгүй.
- УБТЗ-ын байгууллагуудад үйлчилдэг цаг бүртгэлийн системтэйгээс, олон хичээл заадгаас шалтгаалж багшид өөрийгөө хөгжүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх зав чөлөө хомс.

Зөвлөмж:

- Байхгүй.

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Тус хөтөлбөр нь дотооддоо төрийн болон хувийн хэвшлийн, сургалт судалгааны 12 байгууллагатай хамтын ажиллагаатай. Гадаад улсын 12 их дээд сургуулиудтай хамтын ажиллагаатай.
- Багш нар 1999, 2000, 2001, 2011, 2013 онуудад ОХУ-ын Санкт Петербург, Эрхүүгийн Зам Харилцааны Их Сургуульд мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан.
- Хамтын ажиллагааны хүрээнд мэргэжлийн чиглэлийн уралдаан тэмцээн, илтгэл хэлэлцүүлэг зэрэг 31 зүйл арга хэмжээнд оролцсон болон зохион байгуулсан байна.
- Багш оюутнууд ИДС-уудын дундах ЭШОП-ийн хурал болон уралдаан тэмцээнүүдэд (РОБОКОН, ЦТО) оролцсоноор суралцагчийн бүтээлч сэтгэлгээ, багаар ажиллах, илтгэх болон харилцааны, бичгийн чадварууд дээшилсэн байна.
- Мэргэжлийн багш нар ДХМЭХ-ний албаны удирдлага, ИТА-тай хамтран ЭШОП-ийн хурал зохион байгуулсан.
- 2016 оноос УБТЗ-д СИРДП-Е систем нэвтэрч байгаатай холбогдуулан УБТЗ-аас ИТА-уудын хамт багш нарыг шинэ системийн сургалтад хамруулж байна.
- Төгсөгчдийн мэргэжил дээшлүүлэх сургалт хийгддэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Албаны инженерүүдтэй хамтран багш нар мэргэжлийн ном сурах бичиг боловсруулж сургалтад ашиглаж байгаа нь сайн туршлага байна.

Анхаарах асуудал:

- Эрдэм шинжилгээ судалгааны ажлын чиглэлээр цахилгаан холбоо, телемеханик хөтөлбөртэй холбоотой гадаад хамтын ажиллагаа, семинар хийгдсэн байдал харагдахгүй байна.
- Гадаадаас зочин профессор эрдэмтэн урьж хичээл заалгах, лекц уншуулах, хамтран судалгаа хийх тал дээр дутагдалтай байна.
- Компани, байгууллага, сангийн тэтгэлэгт хамрагдсан оюутны тоо цөөн.

Зөвлөмж:

- Дотоодын болон гадаадын их дээд сургуулиудтай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- ТЗДС нь Монгол-Оросын хамтарсан өмчийн сургууль бөгөөд сургуулийн нийт санхүүжилтийн 75% нь сургалтын төлбөр, 8% нь өөрийн бусад орлого, 6% нь Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн орлого, 11% нь УБТЗ-ын татаасын эх үүсвэрээс тус тус бүрддэг байна.
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэсэн шинэчлэлтэд 2017 онд 216 338 000 төгрөгний ажил үйлчилгээг хийсэн байна.
- Санхүүжилтийн хувьд УБТЗ ХНН-ээс бүрэн хараат байдалд байдаг юм байна.
- Анги танхим шинэчлэх, тоноглох, засварлах, шинээр лаборатори байгуулах, тоноглоход санхүүгийн боломж дутмаг, хараат байдалтай байдаг.
- Сургалтын төлбөрийг ТЗ-ын удирдах зөвлөлөөр (удирдах зөвлөлд хоёр яамны төлөөлөл, УБТЗ-ын замын даргын орлогч, ажил олгогчийн төлөөлөл ордог) хэлэлцүүлж тогтоодог.
- Одоогийн байдлаар 1 кр цагийн сургалтын төлбөр 59500 төгрөг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш, ажилтны нийгмийн халамж сайн.
- Дотоодын сургуульд докторын сургалтад сурвал төлбөрийн 50-75%-ийг УБТЗ-аас гаргадаг. Гадаадын сургуульд суралцсан тохиолдолд замын зардлыг нь өгдөг.
- Удаан жилийн нэмэгдлийг 5 жилээс эхлэн тооцдог. Эрдмийн зэрэг цолд цалингийн нэмэгдэл олгодог. Ph.D 15%-ийн, зөвлөх инженер 15%-ийн нэмэгдэлтэй.
- Туршлагатай ахмад багш нар шинэ багшийг халамжлан хүмүүжүүлж ажиллах багш шавийн гэрээ байгуулж ажилладаг.

Анхаарах асуудал:

- Санхүүгийн хувьд ТЗ-аас хараат байгаа нь бие дааж сургуульд төсөл хэрэгжүүлэх, сургалтын орчныг өөрчлөх сайжруулах боломж хязгаарлагдмал, багшийн төсөл, гэрээт ажил хийх эрмэлзлийг бага төрүүлдэг байж магадгүй.

Зөвлөмж:

- Санхүүжилтийн оновчтой механизмыг эрэлхийлэх

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- УБТЗ-ын Хүний нөөцийн алба болон бусад мэргэжлийн алба, салбар нэгжээс ирүүлсэн тухайн мэргэжлийн элсэлтийн хяналтын тоонд үндэслэгдэн элсэлтийн хяналтын тооны санал нэгтгэгдэж гардаг. Мөн хувийн хэвшлийн төмөр замтай холбоотой байгууллага, компанийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаанд үндэслэн оюутан элсүүлдэг.
- Элсэлтийн үйл ажиллагааг төмөр замын дагуух өртөөнүүд болон төвийн хэсэг гэсэн 7 газар зохион байгуулах ажлыг явуулдаг.
- Элсэлт сурталчлах ажлыг жил бүрийн 1-р улиралд багтаан төмөр замын шугам зам дагуух аймаг сумдын ЕБС-ийн төгсөх ангийн сурагчдад хийж элсэх сонирхолтой сурагчдын тандалт судалгааг хийдэг байна.
- Төмөр замын мэргэжил бүрээр ОХУ-ын Иркутск хотын ЗХИС-тай хамтран “2+3” хөтөлбөр хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг 2018-2019 оны хичээлийн жилд хийж 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлэхээр бэлтгэл ханган ажиллаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ОХУ-ын Иркутск хотын ЗХИС-тай хамтран “2+3” хөтөлбөр хэрэгжүүлэх гэж байгаа нь онцлог байна гэж үзлээ.
- Сүүлийн 5 жилийн хугацаанд мэргэжил дээшлүүлэх курс сургалтыг мэргэжлийн чиглэл бүрээр явуулж нийт 258 инженер техникийн ажилтныг хамруулсан байна.

Анхаарах асуудал:

- Байхгүй.

Зөвлөмж:

- Байхгүй.

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрт элсэн суралцуулах танилцуулгыг гаргаж төмөр замын шугам зам дагуу байрлах ЕБС-ийн төгсөх ангийн сурагчдад танилцуулж уулзалт зохион байгуулах,

мэргэжлийн талаар танилцуулга хийх ажлыг сүүлийн 2 жилийн хугацаанд тогтмол хийж ирсэн байна.

- Сургууль болон сургалтын үйл ажиллагаатай холбоотой бүхий л мэдээллийг мэдээлдэг сургуулийн цахим хуудас:

www.rail-inst.mn

<http://www.facebook.com>

Төмөр замын дээд сургууль албан ёсны хуудаст хөтөлбөрийн танилцуулгыг байршуулж хөтөлбөрийн ил тод байдлыг хангасан байна.

- “Мэргэжлийн өдөрлөг” арга хэмжээг жилд 2 удаа зохион байгуулж, ахмад төмөр замчидтай уулзалт зохион байгуулж, ажлын байрыг таниулан сурталчлах ажлыг хийж хэвшсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Шилдэг төгсөгчдөд сонгон шалгаруулалтгүй шууд ажлын байраар хангах “Ажлын эрхийн урилга”-ыг олгодог онцлогтой.
- Төгсөх курсийн окутнуудад зориулсан “Ажил олгогч-Төгсөгчид”-ийн уулзалтыг жил бүр тогтмол хийж хэвшсэн байна.

Анхаарах асуудал:

- Байхгүй.

Зөвлөмж:

- Байхгүй.

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Элсэгчид онлайн хаягаар бүртгүүлж элсэлтийн үйл ажиллагаанд оролцох боломжоор бүрэн хангагдсан.
- Элсэгчид математик болон физикийн хичээлийн аль нэгнээр 480 оноо авсан тохиолдолд элсдэг.
- Элсэлттэй холбоотой бүх мэдээллийг Ган зам сонин, сургуулийн цахим хуудас <https://elselt.insttrans.mn/>, <http://www.rail-inst.mn/> -д мэдээлдэг.
- Дипломын боловсролтой тусгай мэргэжлийн дунд сургууль төгссөн иргэн мэргэжлийнхээ дагуу бакалаврын хөтөлбөрт элсэх хүсэлт гаргасан тохиолдолд түүний өргөдөл, эзэмшсэн мэргэжлийн техникчийн дипломын хуулбарыг үндэслэн элсүүлэх боломжийг нээж өгсөн.
- УБТЗ-ын хүний нөөцийн алба элсэгчдийн тоонд хяналт тавих ба хүйсийн харьцааг элсэхээс өмнө тодорхойлдог байдал, мөн төмөр замын мэргэжлийн байгууллагад ажилладаг ажилтнууд жил бүр эрүүл мэндийн шалгалтаар орж, тэнцсэн тохиолдолд үргэлжлүүлэн ажиллах эрх үүсдэг тул шинээр элсэгчдэд энэхүү шаардлагыг тавьж эрүүл мэндийн үзлэгт тэнцсэн тохиолдолд суралцах эрх үүсдэг явдал нь ирээдүйн боловсон хүчнийг бэлтгэж байна.
- Шинээр элссэн суралцагчдад ТЗДС-ийн тушаал заавар, эрх үүрэг, дүрэм журам бүхий гарын авлагыг зориулан гаргадаг, зөвлөх багш томилж зөвлөн туслуулж ажиллуулдаг,

мөн шинээр элссэн бүх оюутандаа нэгдүгээр курсийн намар “Төмөр замын ерөнхий курс” хичээл орж мэргэжлийн чиг баримжаа олгодог.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Элсэлтийн бодлого, дүрэм журмын дагуу УБ хот болон төмөр замын үндсэн 5 тулгуур өртөө, Дорнод аймгуудаар элсэлтийг тогтмол зохион байгуулдаг.

Анхаарах асуудал:

- Гадаад оюутан элсүүлэх боломж

Зөвлөмж:

- Элсэлтийг тулгуур өртөөнүүдээс гадна бусад аймгуудаас авах боломжийг нэмэгдүүлэх

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутанд туслах зорилгоор зөвлөх багш томилон ажиллуулдаг бөгөөд зөвлөх багш нарын зүгээс нийт хөтөлбөрийн оюутнуудын дунд хэрэгжүүлдэг арга хэмжээ нь тогтворжсон ахиц дэвшилттэй харагдаж байна.
- ТЗДС-ийн зүгээс суралцагчдад зориулж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, хичээлээс гадуурх сургалтын ажлын төлөвлөгөөг хичээлийн жилийн эхэнд гарган шат дараатай хэрэгжүүлж ажилладаг нь зөв зүйтэй байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөх ангийн оюутнуудыг ажил олгогчидтой уулзуулж, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зөвлөгөө мэдээлэл өгч ажилладаг.
- Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааг гаргаж, төгсөгчидтэйгөө эргэх холбоотой байж, тэдэнд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажилладаг. Сүүлийн 5 жилд УБТЗ-ын дохиолол холбоо сүлжээ эрчим хүчний албатай хамтарч мэргэжил дээшлүүлэх курс сургалтыг 258 төгсөгчийг хамруулсан байна.

Анхаарах асуудал:

- Байхгүй.

Зөвлөмж:

- Оюутанд чиглэсэн үйлчилгээтэй холбоотой санал асуулгыг хичээлийн жилийн улирал тутамд тогтмол явуулж хэвших. Судалгааны үр дүнд тулгуурлан, нэгдсэн төлөвлөгөөт ажлуудыг зохион байгуулж хэвших.
- Зөвлөн туслах үйлчилгээнд Зөвлөх багшийн төлөвлөгөө, үйлчилгээний чанарт өгсөн сэтгэл ханамжийн судалгаа авч дүн шинжилгээ хийдэг байх.
- Суралцагчдад зориулсан орчин (разетка, цэнэглэгчтэй, wifi-тэй) буюу гар утас компьютерээ цэнэглэх булан, вестибюль тохижуулах.

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутны техник сэтгэлгээ, харилцааны ур чадварыг хөгжүүлэх зорилготой 3 клуб ажиллаж байна.
- Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийг байгуулан Нийслэлийн хөдөлмөрийн газар болон бусад байгууллагатай хамтран ажиллах, сургалтад хамруулах, цагийн ажилд

- зуучлах, сурталчилгаа хийх, цагийн ажилд орох хүсэлтэй оюутнуудын судалгаа авах, зөвлөгөө өгөх зэрэг үйл ажиллагаа явуулж байгаа ба ихэвчлэн дотуур байранд амьдардаг, амьдралын боломж тааруу оюутнуудыг хамруулж дэмжин ажилладаг.
- Олимпиад, уралдаан тэмцээнд 2017-2018 оны хичээлийн жилд 20 оюутан оролцсон бөгөөд 1-р байр 11 оюутан, 2-р байр 4 оюутан, 3-р байр 5 оюутан эзэлсэн. Мөн 2018-2019 оны хичээлийн жилд 4 оюутан оролцсон бөгөөд 1-р байр 2 оюутан, 2-р байр 2 оюутан эзэлсэн байна.
 - Оюутны урамшууллыг УБТЗ-ын даргын 2018 оны 11 сарын 14–ний өдрийн А/525 тоот тушаалын “Оюутныг урамшуулах тухай” журмаар зохицуулдаг.
 - Олимпиад, уралдаан тэмцээнд амжилттай оролцож эхний гурван байранд шалгарсан, захирлын нэрэмжит хуудсанд бичигдсэн болон оюутнуудын сайн дурын, мэргэжлийн клубүүдийн үйл ажиллагаанд оролцсон байдлыг үнэлж, кредитийн урамшуулал олгодог явдал нь оюутнуудыг урамшуулж, идэвхжүүлэх, амжилт гаргахад нь тус дэм болж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Тус хөтөлбөрөөс Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлгийг амжилттай сурч хөдөлмөрлөн, үлгэр жишээ онцгой амжилт гаргасан 2 оюутан, Тайваний Засгийн газрын нэрэмжит тэтгэлгийг 1 оюутан хүртсэн байна.

Анхаарах асуудал:

- Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажил, цагийн ажил, үндсэн ажилд зуучилсан төгсөгч, оюутны тоон мэдээлэл зэргийг сайн гаргаж мэдээлдэг байх.
- Багш нараас оюутны клубийг удирдан чиглүүлэх гэх зэрэг хүмүүжил төлөвшлийн ажилд оролцоо жигд бус.
- Компани, байгууллага, сангийн тэтгэлэгт хамрагдсан оюутны тоо цөөн.

Зөвлөмж:

- Компани, байгууллага, сангийн тэтгэлгүүдийг оюутнуудад сайн сурталчлах.

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- ТЗДС-ийн захирлын 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А-190 тоот тушаал “Бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-аар шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудлыг шийдвэрлэдэг.
- Тус хөтөлбөрт сүүлийн 5 жилийн шилжилт хөдөлгөөний судалгаа хийгдсэн бөгөөд тухайн жилүүдэд 133-145 оюутан суралцаж байсан бөгөөд шилжилт хөдөлгөөн нь 23-38 байсан.
- Оюутан өөрийн сонирхолдоо нийцсэн мэргэжил, сургуулиа сонгох үүднээс гадаадын зам харилцааны их, дээд сургууль болон магадлан итгэмжлэгдсэн дотоодын их дээд сургуулиудаас мөн ТЗДС-ийн бакалаврын сургалтын хөтөлбөр хооронд шилжин суралцахыг зөвшөөрдөг нь оюутны эрх ашигт нийцсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрөөр суралцагчдын шилжилт хөдөлгөөний сүүлийн 5 жилийн судалгаанаас харахад жилийн чөлөө авсан оюутны тоо өмнөх жилүүдээс харьцангуй буурсан, сургуулиас гарсан оюутны тоо өмнөх жилүүдээс мөн буурсан үзүүлэлттэй байна.

Анхаарах асуудал:

- Судалгаанд дүн шинжилгээ хийх

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- Оюутан төгсөлтийн өмнөх улиралд сургалтын хөтөлбөрт заасан нийт кредитийн 110-аас багагүйг цуглуулсан, 2.0-оос багагүй голч дүнтэй суралцсан тохиолдолд төгсөх оюутнаар системд бүртгэгдэнэ
- Голч дүн 2.5 ба түүнээс дээш тохиолдолд өөрөө хүсвэл дипломын төсөл бичиж, төгсөлтийн ажлаа хамгаалахыг зөвшөөрнө.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ТЗДС нь төгсөгчдийг “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” тусгай сургалтад хамруулж сертификат олгодог онцлогтой.

Анхаарах асуудал:

- Улсын шалгалт өгсөн болон төгсөлтийн ажил бичиж төгссөн оюутнуудын суралцахуйн үр дүнгийн судалгааг хийх

Зөвлөмж:

- Байхгүй.

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- Бакалавр оюутны тоо 107, хөтөлбөрийн нийт багшийн тоо 26 байгаа нь “Дээд боловсролын байгууллагад тавих нийтлэг шаардлага”-ын багш суралцагчдын тооны харьцаа зохистой хэмжээнд байна.
- Багшийн албан тушаалын зэрэглэлд тавигдах шаардлагыг “УБТЗ” ХНН-ийн Замын даргын 2018 оны А-525 тоот тушаалаар батлагдсан журамд зааснаар шийдвэрлэдэг.
- Багшийн ажлыг дүгнэх шалгуурыг тус сургуулийн захирлын 2015 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 139 тоот тушаалаар батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу жил бүр дүгнэдэг.
- Тус хөтөлбөрт хичээл заадаг багш нарын 20% нь доктор, 27% нь докторант, 53% нь магистр зэрэгтэй багш байгаагаас докторын зэрэгтэй багш нар нь бүгд суурь боловсролын хичээлүүд зааж байгаа багш нар байна.
- Мэргэжлийн хичээл зааж буй багш нар одоогоор хараахан докторын зэрэг хамгаалаагүй байгаа хэдий ч мэргэжлийн мэдлэг, чадвар сайтай, туршлагатай.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ТЗДС багш нарт үзүүлэх нийгмийн халамж, дэмжлэг сайтай нь: шинэ барилгын үнэлгээг хөнгөлөлттэй нөхцөлөөр багш нараа орон сууцтай болгосон, галт тэргээр жилд 1 удаа үнэгүй зорчих эрх олгодог, шагналт цалин сар бүр өгдөг, мөн 13 дахь сарын цалин олгодог, докторын сургалтын төлбөрийн 50%, 75%-ийн дэмжлэг үзүүлдэг, эмнэлэг,

хүүхдийн цэцэрлэг сургуулиар хангадаг, ажилласан жилийн, зэрэг цолны нэмэгдэл олгодог зэргээс харагдаж байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн мэргэжлийн багшийн тоо цөөн, ачаалал ихтэй.
- Эрдмийн зэрэг, цолтой багшийн тоог нэмэгдүүлэх.
- Багш болон албан тушаалтныг ажилд томилох, ажлаас чөлөөлөх асуудалд сургуулийн удирдлагын шууд оролцоог хангах, ялангуяа доктор зэрэгтэй багш ажилд авах асуудалд анхаарах.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн мэргэжлийн багшийг доктор зэрэгтэй багшаар нэмэгдүүлэх, ачааллыг тэнцвэржүүлэх.
- Багшийн илүү гүйцэтгэсэн Б, В цагийг урамшуулдаг системтэй болох.

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн багш нарын мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадварыг хөгжүүлэхийн тулд судалгаа авч, түүнийхээ дагуу сургалтуудыг тасралтгүй зохион байгуулдаг.
- 2018, 2019 онд “Үр дүнд суурилсан боловсролын CDIO стандарт, арга зүйг түгээн дэлгэрүүлэх” I, II шатны сургалтад мэргэжлийн гурван багш хамрагдаж сургалтандаа энэхүү арга зүйг ашиглаж байна.
- Хөтөлбөрийн багш нарын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр мэргэжил дээшлүүлэх курс, семинарт суралцуулахад дэмжлэг үзүүлэхээс гадна докторын сургалтад суралцаж буй багшид докторын сургалтын танхимын цагийн 50 хүртэлх хувь, судалгааны ажлын 75 хүртэлх хувьтай тэнцэх төлбөрийн тэтгэлэг, диссертацаа бичих, хамгаалах үед тухайн докторантад суралцах хугацаанд нэг удаа 2 хүртэлх сарын үндсэн цалинтай бүтээлийн чөлөө олгодог байна.
- Судалгаа эрдэм шинжилгээний ажлыг нэг багшид ногдох хөгжлийг харахад өссөн үзүүлэлттэй байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийн хөгжлийн хөтөлбөр боловсруулан ажиллаж байна.
- 2017-2019 онд ТЗДС-ийн ҮЭ-ийн хорооны зүгээс нийт 16 сургалт зохион байгуулсан бөгөөд хөтөлбөрийн багш нар хамрагдсан.

Анхаарах асуудал:

- Багш нарын цагийн ачаалал их байдгаас өөрийгөө хөгжүүлэх, эрдэм шинжилгээний ажил хийх цаг хомс.

Зөвлөмж:

- Багш нарын өөрийгөө хөгжүүлэх, эрдэм шинжилгээний ажил хийх боломжийг нэмэгдүүлэхийн тулд сургалтын мастер, лабораторийн туслах ажилтантай болох замаар багшийн цагийн ачааллыг багасгах.

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн мэргэжлийн багш нар ЗТХЯ, УБТЗ-ын ХНН, Дохиолол холбооны алба, бусад аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн захиалгат ажил, төсөл хөтөлбөрүүдийн багт орж

бүтээлч ажлуудыг хийж гүйцэтгэсэн ба сүүлийн 5 жилийн байдлаар 4 төсөлд мэргэжлийн 3 багш оролцсон байна.

- Сүүлийн 3 жилд хөтөлбөрийн мэргэжлийн багш нар эрдэм шинжилгээний хуралд 9 илтгэл хэлэлцүүлж, эрдэм шинжилгээний бүтээл хэвлүүлсэн, мөн оюутны эрдэм шинжилгээний бүтээлүүд удирдсан байгаа нь мэргэжлийн багш нарын цагийн ачаалал хэдий их байгаа ч эрдэм шинжилгээний ажлыг орхигдуулаагүй нь харагдаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Байхгүй.

Анхаарах асуудал:

- Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, ашигтай загвар, патент байхгүй.
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зарцуулсан төсөв, тайлангийн талаарх мэдээлэл тусгагдаагүй.
- Олон улсад нийтлүүлсэн бүтээл хангалтгүй.

Зөвлөмж:

- Багш нарыг судалгаа шинжилгээний ажил хийх боломжоор хангах, эрдэм шинжилгээ судалгааны ажлын онцгой хөтөлбөр хэрэгжүүлэх (олон улсын нэр хүнд бүхий мэргэжлийн сэтгүүлүүдэд өгүүлэл хэвлүүлэхэд болон бүтээл нь эшлэгдэх тохиолдолд урамшуулал олгодог гэх мэт.)

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- ТЗДС-ийн хөтөлбөрийн чанарын үнэлгээний журмын дагуу багш бүр өөрийгөө үнэлэхээс гадна сургалтад оролцогч нараас багшийн ажлыг заавал дүгнүүлэхээр Unimis-д оруулсан.
- ТЗДС-ийн багш нарын ажлыг дүгнэх шалгуурыг тус сургуулийн захирлын 2015 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн 139 тоот тушаалын батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу жил бүр тухайлсан хугацаанд дүгнэж, үр дүнг мэдээлдэг. Үнэлгээний шалгуур нь Сургалтын үйл ажиллагаа, Эрдэм шинжилгээ судалгаа төслийн ажил, Нийгэмд чиглэсэн болон бусад гэсэн үндсэн хэсгүүдээс бүрдэнэ. Нийт 200 оноогоор дүгнэдэг.
- Багшийн үйл ажиллагааг мэдлэг оюуны чадамж, хувь хүний чадамж, судалгааны чадамж, сургахуйн чадамж бүхий дөрвөн үзүүлэлтээр багш бүр өөрийгөө үнэлэхээс гадна сургууль болон салбар/тэнхимийн удирдлагаас багшийг, хөтөлбөрт оролцогч багш багшаа, хөтөлбөрөөр суралцагч оюутан багшаа, төгсөгч нь багшаа үнэлдэг байдал нь тухайн багш өөрийгөө ямар түвшинд байгааг мэдэж, дүн шинжилгээ хийж, өөрийгөө хөгжүүлэх зорилготой болж байгаа тул сайн гэж дүгнэж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн нийт 17 багшийг оюутнуудаар үнэлүүлсэн үнэлгээг гаргасан байна.
- Багш бүр өөрийн намтар, мэдлэг боловсролын үйл ажиллагааны баримт, материалыг агуулсан хавтастай байна.

Анхаарах асуудал:

- Багшийн товч намтар (CV) оруулах /Монгол-Орос-Англи/
- Багш нарын ажлын туршлага, судалгааны ажлын чиглэлийг вэб-д байршуулах /Монгол-Орос-Англи/

Зөвлөмж:

- Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, туршилт судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний чиглэлээр хичээлийн жил тутамд өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байх.

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- ТЗДС-ийн захиралын тушаалаар 11 хүний бүрэлдэхүүнтэй хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын баг байгуулж үйл ажиллагаагаа эхлүүлж байна.
- Хөтөлбөрийн чанарын үнэлгээний журам, Чанарын дотоод баталгаажилтын багийн ажиллах журам зэргийг боловсруулсан байна.
- Чанарын баталгаажуулалтын чиглэлээр хийсэн ажлын тайлан мэдээ байна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Байхгүй

Анхаарах асуудал:

- Чанарын дотоод баталгаажилт хийх тогтсон графикчилсан хөтөлбөр төлөвлөгөө харагдахгүй байна.
- Хөтөлбөрийн чанарын баталгаажилт хийх, төгсөгчдийн суралцахуйн үр дүнгийн хүрсэн түвшинг үнэлэх хөндлөнгийн үнэлгээний механизм байхгүй байна.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн биелэлтийг үнэлж, дүгнэж, сайжруулалтын санал зөвлөмж гаргаж байдаг ажил олгогч болон төгсөгчдийн төлөөллөөс бүрдсэн албан ёсны хөтөлбөрийн мэргэжлийн зөвлөлийг байгуулах.
- Хөтөлбөрийн мэргэжлийн зөвлөлийн ажлыг тогтмолжуулан, тухайн хичээлийн жилийн эцэст хөтөлбөрийн чанар, үр дүн ямар байгааг хэлэлцүүлэг хийх замаар үнэлэлт дүгнэлт өгдөг байх, хөтөлбөрийн сайжруулалтад эргэх холбоотой байх.

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, карьер өсөлтийн судалгаа, ажлын байрны тогтворжилтын судалгаа зэрэг судалгаануудыг 1 удаа хийсэн байна.
- 2017 оны 12 сард нийт 44 удирдлага /ажил олгогч/-аас хөтөлбөрөөр төгсөгчдийн үр чадварын талаар санал асуулга 1 удаа авсан байна.
- Ажил олгогчдоос авсан санал асуулгаар төгсөгчдийн мэдлэг, үр чадварын талаар сэтгэл ханамжийн дүн шинжилгээ хийсэн байна. 57 хувь нь төгсөгчдийн мэдлэг чадвар дунд зэрэг гэж үзсэн байна.
- Хөндлөнгийн үнэлгээний асуултуудын хариултын эрэмбэ учир дутагдалтай, судалгаанд хийсэн дүн шинжилгээ дутуу дулимаг байна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Байхгүй

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрөөр эзэмшүүлэх 15 суралцахуйн үр дүнг төгсөгч хэр зэрэг эзэмшсэн талаарх үнэлэх үнэлгээний аргачлал байхгүй байна.
- Хичээл бүрээр оюутанд эзэмшүүлэх мэдлэг, хандлага, ур чадвар буюу хичээлийн суралцахуйн үр дүнг тодорхойлсон боловч төгсөгчийн суралцахуйн үр дүнтэй холбож өгөөгүй байна.
- Төгсөгчийн суралцахуйн үр дүнг хичээлийн үр дүнгээр хэрхэн үнэлэх аргачлал гаргаагүй байна. Өөрөөр хэлбэл хөтөлбөрийн өөрийн шууд үнэлгээ хийх аргачлалаа тодорхойлоогүй байна.
- Төгсөгчдийн чанарыг зөвхөн ажил олгогчдын санал асуулгаар буюу шууд бус аргаар үнэлэх оролдлого хийж эхэлсэн байна. Хөтөлбөр төлөвлөсөн үр дүндээ хүрч чадсан эсэхийг зөвхөн санал асуулгаар тодорхойлох нь өрөөсгөл талтай, шууд үнэлгээ зайлшгүй шаардлагатай.
- Санал асуулга, судалгааны үр дүнд үндэслэн хөтөлбөрийг сайжруулах төлөвлөлт хийгдээгүй байна.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн үр дүн буюу төгсөгчдийн эзэмших суралцахуйн үр дүнг санал асуулгаас гадна хичээлээр үнэлдэг болох, хичээлүүдийн суралцахуйн үр дүнг төгсөгчийн суралцахуйн үр дүнтэй холбох.
- Хичээлийн суралцахуйн үр дүнгээр төгсөгчийн суралцахуйн үр дүнг үнэлдэг аргачлал боловсруулах, уг аргачлал дотор төгсөгчийн эзэмшсэн суралцахуйн үр дүнг хангалттай гэж үзэх үнэлгээний босгыг оновчтой тогтоох.
- Хичээл бүрийн оюутанд эзэмшүүлэх суралцахуйн үр дүнг рубрикээр үнэлдэг болох, үнэлгээний рубрикийг тодорхойлох.
- Хичээл бүрээр хичээлийн жил тутамд оюутны эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагад үнэлгээ хийж тайлан гаргах, улмаар хичээлүүдийн үр дүнгээр төгсөгчийн суралцахуйн үр дүнг үнэлж үнэлгээний босгод хүрсэн эсэхийг тогтоодог байх.
- Хангалттай босгод хүрээгүй суралцахуйн үр дүнг сайжруулахын тулд ямар ажлыг хэзээ, хэрхэн хийхийг тусгасан төлөвлөгөө гарган ажилладаг байх.

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- ТЗДС-ийн хувьд 4 удаа байгууллагын магадлан итгэмжлэлээр амжилттай итгэмжлэгдсэн байна.
- Харин энэ хөтөлбөр нь анх удаа магадлан итгэмжлэл хийлгэж байгаа хөтөлбөр болно.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Байхгүй

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Хэсэгчлэн хангасан

ДҮГНЭЛТ

Төмөр Замын дээд сургуулийн “Төмөр замын цахилгаан холбоо, телемеханик” /D071403/

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаа-гүй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	2			Шалгуурын шаардлагуудыг бүрэн хангасан.
2	Сургалтын үйл ажиллагаа	2			Шалгуурын шаардлагуудыг бүрэн хангасан.
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	2			Зарим үзүүлэлт шалгуурыг хэсэгчлэн хангасан боловч бүхэлдээ шалгуурын шаардлагуудыг бүрэн хангасан.
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	2			Шалгуурын шаардлагуудыг бүрэн хангасан.
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	2			Шалгуурын шаардлагуудыг бүрэн хангасан.
6	Багшийн үйл ажиллагаа	2			Зарим үзүүлэлт шалгуурыг хэсэгчлэн хангасан боловч бүхэлдээ шалгуурын шаардлагуудыг бүрэн хангасан.
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт		1		Хөтөлбөрөөр төгсөгчдөд эзэмшүүлэх суралцахуйн үр дүнг төгсөгч хэр зэрэг эзэмшсэнийг үнэлэх шууд ба шууд бус үнэлгээний аргачлал байхгүй байна. Хичээл бүрээр оюутанд эзэмшүүлэх мэдлэг, хандлага, ур чадвар буюу хичээлийн суралцахуйн үр дүнг төгсөгчийн суралцахуйн үр дүнтэй холбож өгөөгүй байна. Хөтөлбөр төлөвлөсөн үр дүндээ хүрч чадсан эсэхийг зөвхөн санал
Дүгнэлт		Бүрэн хангасан			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Төмөр Замын Дээд сургуулийн “Төмөр замын цахилгаан холбоо, телемеханик” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлтийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагч: З.Буянхишиг

Шинжээчийн багийн гишүүн: Ж.Хүрэл

Шинжээчийн багийн гишүүн: Д.Мянганбаатар

ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ

ТЗДС-ийн “Төмөр замын цахилгаан холбоо, телемеханик” бакалаврын хөтөлбөрт үнэлгээ хийсний үндсэн дээр шинжээчийн багаас уг хөтөлбөрийн үйл ажиллагааг сайжруулах дараах зөвлөмжүүдийг өгч байна. Үүнд:

1. Хөтөлбөрөөр төгсөгчийн суралцахуйн үр дүн буюу эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг илүү оновчтой болгон, давхардлыг арилгаж, төгсөгчдөд эзэмшүүлэх суралцахуйн үр дүнг эрэмбэлэх
2. Дохио дамжуулах онол, мэдээллийн технологи ба сүлжээ, дамжуулах систем зэрэг мэргэжлийн суурийн болон мэргэшүүлэх хичээлүүдийн агуулгыг сайжруулж орчин үеийн тоон техник шинэ дэвшилтэт технологийн талаар түлхүү оруулах, хичээлийн лекцийг бэлтгэхдээ мэдээлэл холбооны дэвшилтэт технологиудыг ашиглах
3. Мэргэжлийн хичээлийн дадлага хийхэд зориулагдсан орчин үеийн тоноглол бүхий лабораторитой болох
4. Номын санд болон вестибюльд компьютер бүхий интернет уншлагын булантай болж, оюутнуудын хичээл сонголт хийх, интернетээс мэдээлэл олж авах боломжийг нэмэгдүүлэх, суралцагсдад зориулсан орчин (разетка, цэнэглэгчтэй, wifi-тэй) буюу гар утас компьютерээ цэнэглэх булан, вестибюль тохижуулах
5. Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, туршилт судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний чиглэлээр хичээлийн жил тутамд өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байх.
6. Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн биелэлтэд үнэлгээ дүгнэлт өгч, сайжруулалтын санал зөвлөмж гаргаж байдаг ажил олгогч болон төгсөгчдийн төлөөллөөс бүрдсэн албан ёсны хөтөлбөрийн мэргэжлийн зөвлөлийг байгуулах, үйл ажиллагааг нь тогтмолжуулан, тухайн хичээлийн жилийн эцэст хөтөлбөрийн чанар, үр дүн ямар байгааг хэлэлцүүлэг хийх замаар үнэлэлт дүгнэлт өгдөг байх, хөтөлбөрийн сайжруулалтад эргэх холбоотой байх

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Ажилласан жил	Заадаг хичээл
Суурь боловсролын тэнхим					
1	Н.Сарантуяа	Тэнхимийн эрхлэгч	Физикийн ухааны доктор	2	Физик
2	Д.Энхтуяа	Ахлах багш	Химийн ухааны доктор	39	Хими
3	С.Ариунболд	Ахлах багш	Техникийн ухааны доктор	21	Хий шингэний хөтлүүр, Машин механизмын онол, Онолын механик
4	Р.Содномцэрэн	Ахлах багш	Түүх, нийгмийн ухааны доктор	1	Хүний хөгжил, харилцааны ёс зүй
5	Д.Бүдсүрэн	Ахлах багш	Хэл шинжлэлийн ухааны доктор	1	Монголын түүх, соёл, ёс заншил
6	П.Бямбахорол	Ахлах багш	Хэл шинжлэлийн ухааны доктор	1	Монгол хэл, бичиг, найруулга зүй
7	Э.Пүрэвдалай	Ахлах багш	Техникийн ухааны доктор	1	Термодинамик, дулаан дамжуулалт
8	Б.Баасанням	Ахлах багш	Магистр	24	Алгоритм програмчлалын үндэс

9	Д.Алтанцэцэг	Ахлах багш	Магистр	34	Сэтгэлгээний түүх соёл, Монголын түүх, соёл, ёс
10	Г.Золчимэг	Ахлах багш	Магистр	23	Биеийн тамир
11	М.Энхбаяр	Ахлах багш	Магистр	24	Эдийн засгийн онол
12	П.Наранхишиг	Багш	Магистр	17	Техникийн зураг зүй, Дүрслэх геометр
13	Д.Чулуунцэцэг	Багш	Магистр	8	Микроконтроллёрын програмчлал, Ассемблер хэл, Програмчлалын хэл, Мэдээллийн технологи
14	М.Бямбасүрэн	Багш	Магистр	7	Математик
15	Д.Номинчулуун	Багш	Магистр	7	Математик
16	П.Баттөгс	Багш	Магистр	10	Техникийн зураг зүй CAD, Техникийн оношлол
17	О.Жамъян	Дадлагажигч багш	Магистр	4	Техникийн хэмжил зүй ба харилцан солилцол, Материал судлал
18	Ц.Хувьзаяа	Дадлагажигч багш	Магистр	4	Дүрслэх геометр, Техникийн зураг зүй
19	Б.Танхилсайхан	Дадлагажигч	Магистр	3	Физик
20	С.Ерөөлт	Дадлагажигч багш	Бакалавр	2	Дугуйлан, секц
21	Ч.Нямбаяр	Дадлагажигч багш	Магистр	2	Хийцийн материал боловсруулах технологи
22	Ц.Золзаяа	ХТА	Магистр	2	
Хэл, соёлын тэнхим					
1	Н.Одгэрэл	Тэнхимийн эрхлэгч	Магистр	28	Англи хэл
2	Х.Цацрал	Ахлах багш	Магистр	20	Англи хэл
3	Б.Дөлгөөнжаргал	Ахлах багш	Магистр	8	Англи хэл
4	Б.Татьяна	Багш	Магистр	2	Орос хэл
5	Б.Сувд-Эрдэнэ	Багш	Магистр	4	Орос хэл
6	Б.Баяржаргал	Багш	Магистр	2	Орос хэл

II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал	Утас
1	Б.Төгөлдөр	Ш-4 анги	Өмнөговь, Даланзадгад, 6-р баг, начин, их-уул, 3-13 тоот	88699555
2	О.Баттөгөлдөр	Ш-4 анги	Дархан-Уул, Дархан, 6-р баг, ханжаргалан, 14-1 тоот	86560070
3	Б.Мичидмаа	Ш-4 анги	УБ, БГД 16-р хороо, туул 9-179 тоот	89714373
4	Ж.Өлзийдэлгэр	Ш-4 анги	УБ, СХД 9-р хороо	80252602
5	Х.Рэнчинханд	Ш-4 анги	УБ, БЗД 17-р хороо, эмнэлгийн 9-422а тоот	80409667
6	Э.Саранзаяа	Ш-3 анги	Орхон аймаг, Баян-Өндөр сум, Оюут баг, 2-23-96	88878053
7	Б.Энхжин	Ш-3 анги	СХД 7-р хороо Монлаа 2-44	99718068
8	Б.Бямбасүрэн	Ш-3 анги	БЗД 2-р хороо 1-97 тоот	88906789
9	А.Биндэргарав	Ш-3 анги	Булган аймаг, Дашинчилэн сум, 2-р баг УЗН	95831224

10	Б.Сүхбат	Ш-3 анги	Төв аймаг, Батсүмбэр сум, 1-р баг, Суварга 9-50 тоот	80999848
11	Б.Ангарагбанзад	Ш-3 анги	Архангай аймаг, Тахир сум, 4-р баг, 2-2	99229511
12	Б.Дэлгэрнаран	Ш-2 анги	Улаан загалмай сайн дурын байгууллага	80141040
13	О.Баярчимэг	Ш-2 анги	Сэлэнгэ, Жавхлант	95969554
14	Б.Галсанбаяр	Ш-2 анги	Орхон, Баян-Өндөр	98999082
15	Г.Энхболд	Ш-2 анги	Орхон, Жаргалант	99968975
16	Б.Билэгдэмбэрэл	Ш-2 анги	Дотуур байранд амьдардаг, Түгээмэл хөгжил ТББ-д байдаг	95289899
17	Э.Цэцэгмаа	Ш-1 анги	УБ, ЧД 18-р хороо, Согоотын 28-40 тоот, УЗН	88240262
18	А.Энхдэлгэр	Ш-1 анги	Орон нутгийнх, дотуур байранд, Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 2-р баг, Өгөөмөрийн 145 тоот	80150616
19	Б.Мөнх-Эрдэнэ	Ш-1 анги	Орон нутгийнх, СБД 11-р хороо, Хангай хотхон 507-65 тоот, УЗН	80002461

III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага, албан тушаал	Утас
1	Д.Мөнхбуянт	ДХСЭХ-ний алба, Ерөнхий инженер	86114601
2	Д.Батнасан	ДХСЭХ-ний алба, ДТХ хариуцсан инженер	99104608
3	Д.Болорханд	ДХСЭХ-ний алба, Сургалт хариуцсан инженер	99759923
4	М.Энхтайван	ШЧ-2 ангийн ерөнхий инженер	86114641
5	О.Насанбат	ШЧ-2 ангийн ДТХ хариуцсан инженер	86114643
6	Б.Бадрах	ШЧ-2 анги, холбооны байшингийн ахлах	99106945
7	Б.Баттөр	ШЧ-2 анги, КИП, СЦБ-ийн ахлах	86114614
8	Д.Эрдэнэхүү	ШЧ-2 анги, КИП холбооны ахлах	99863419
9	О.Мөнхнасан	ШЧ-2 анги, Боловсон хүчин	95854639
10	Д.Хатанзориг	ШЧ-3 ангийн дарга	86114680, 99104962
11	Б.Амгаланбаяр	ШЧ-3 ангийн ДТХ хариуцсан инженер	86114683
12	Г.Амарбаясгалан	ШЧ-3 анги, КИП холбооны ахлах	99996744
13	Д.Тунгалаг	ШЧ-1 анги, КИП холбооны ахлах	99998069
14	Даваасүрэн	ШЧ-1 ангийн ҮХ-ны дарга	99781201

IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага, албан тушаал	Утас
1	О.Лхагважаргал	2012	“Монкабель системс” ХК, борлуулалтын инженер	90004100
2	Д.Нармандах	2012	Дохиолол холбооны 2-р анги, ЛАЗ-ын механик	88055562
3	Б.Оюунтунгалаг	2012	Дохиолол холбооны 2-р анги, КИП СЦБ-ын механик	99028756
4	Б.Гантулга	2013	Дохиолол холбооны 2-р анги, СИРДП-Е төслийн инженер	86114607
5	Б.Мянганбаяр	2014	АТМ-ын инженер	94090007

6	Ц.Ичинхорлоо	2014	Дохиолол холбооны 2-р анги, шугамын хэсгийн механик	89151589
7	Ө.Онон	2014	Дохиолол холбооны 2-р анги, шугамын хэсгийн механик	88052605
8	Х.Анхбаяр	2015	Дохиолол холбооны 2-р анги, шугамын хэсгийн механик	99993093
9	М.Хажидсүрэн	2015	БЗД-ийн цагдаагийн 3-р хэлтэс, холбоо мэдээллийн инженер	86069607
10	Г.Анарболд	2015	Дохиолол холбооны 2-р анги, ШНС-2-ын механик	99282172
11	Н.Гантулга	2016	Дохиолол холбооны 2-р анги, КРП-ын механик	99136657
12	Х.Очирхуяг	2017	Дохиолол холбооны 2-р анги, ШНС-5-ын механик	89094939
13	Б.Мөнхтулга	2017	Дохиолол холбооны 2-р анги, ШНС-2-ын монтёр	88802333
14	А.Эрдэнэбулган	2017	ТЭЦ-4 Төмөр замын дохиолол холбоо хариуцсан монтёр	99308772
15	Э.Бат-Эрдэнэ	2018	Дохиолол холбооны 2-р анги, шугамын хэсгийн монтёр	94261571

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал


**УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ
ТӨМӨР ЗАМЫН ДЭЭД СУРГУУЛЬ**
 210535 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг
 Энхтайвны ергэн чаруу 44, Утас: 24-22-60, Факс: 24-22-70
 E-mail: rail-inst@ubtz.mn

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
 ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД

2019.05.30 № 42/324
 танай _____-ны № _____-т

Хариу хүргүүлэх тухай

2019 оны 05 дугаар сарын 16,17-ны өдрүүдэд БМИҮЗ-ийн шинжээчийн баг /ахлагч Э.Буянхшиг, гишүүд Ж.Хүрэл, Д.Мянганбаатар нар/ ТЭДС-ийн "Төмөр замын цахилгаан холбоо, телемеханик" мэргэжлийн бакалаврын сургалтын хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийж, бодит байдал дээрх сургалтын үйл ажиллагаатай танилцаж ажилласан.

2019 оны 05 дугаар сарын 28-ны өдөр ирүүлсэн "Шинжээчийн тайлан"-г хүлээн авч, уншиж танилцлаа. Шинжээчийн багийн гаргасан дүгнэлт, тайланд тусгагдсан анхаарах зүйлс, зөвлөмжүүдийг хүлээн авч байна. Цаашид тайланд тусгагдсан зөвлөмжийн дагуу сайжруулах чиглэлийн ажлыг тогтмол хугацаанд, шат дараалалтай хийж гүйцэтгэх болно.

Сургалтын хөтөлбөр магадлан итгэмжлэх ажилд хамтран ажиллаж, үнэтэй зөвлөгөө өгч, сургалтын үйл ажиллагааг сайжруулахад сэтгэл гарган ажилласан та бүхэнд талархсанаа илэрхийлье.

ЗАХИРАГ  Ж.ПҮРЭВСҮРЭН


162190256

ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/

ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)
[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/